



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 42

Сангийндалай

Хамтарсан баг шинэчлэн
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.4, 18.1.5 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлж таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх мэргэжлийн үйлчилгээ үзүүлж эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ цогцоор нь авч хэрэгжүүлэх үүрэг чиглэл бүхий хамтарсан багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Багийн ахлагч: Сумын Засаг дарга
Нарийн бичиг: Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэн
Гишүүдэд: Засаг даргын орлогч
Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Цагдаагийн хэсгийн дарга
Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
Хүүхдийн цэцэрлэгийн эмч
Ерөнхий боловсролын сургуулийн захирал
Ерөнхий боловсролын сургуулийн эмч
Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан
Эрүүл мэндийн төвийн дарга
Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан
1-р багийн Засаг дарга
2-р багийн Засаг дарга
3-р багийн Засаг дарга
4-р багийн Засаг дарга
5-р багийн Засаг дарга
6-р багийн Засаг дарга
7-р багийн Засаг дарга

2. Хамтарсан багийн ажлын төлөвлөгөөг жил бүрийн оны эхний нэгдүгээр сард багтаан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг хамтарсан баг (Б.Лхагвамандал)-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 21 дүгээр "Хамтарсан баг байгуулах тухай" тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ЧУЛУУН